

ТАНИЛЦУУЛГА

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар

Нэг. Татварын ерөнхий газрын статистик мэдээгээр Монгол Улсад 2017 оны байдлаар бүртгэлтэй 155,065 аж ахуйн нэгжээс 78,585 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн 86 хувь буюу 67,612 нь жижиг, дунд үйлдвэрийн салбарт хамаарч, 800 гаруй мянган хүн ажиллаж байгаа нь нийт ажиллах хүчний 57 хувийг эзэлж байна. Ажиллагсдыг тооны бүлгээр авч үзвэл нийт жижиг, дунд үйлдвэрийн 88,6 хувь нь 1-9 хүртэл, 6 хувь нь 10-19 хүртэл, 3,6 хувь нь 20-49 хүртэл, 1,8 хувь нь 199 хүртэл ажиллагсадтай байна. Борлуулалтын орлогын ангиллаар авч үзвэл 1,5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдээс 50 хүртэл сая төгрөгийн борлуулалттай нь 59 хувь буюу жижиг, дунд үйлдвэрийн талаас илүү хувь нь бичил үйлдвэрлэл эрхлэгч байна.

Улсын хэмжээнд 2009-2017 оны хооронд Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санд 3 их наяд 850,5 тэрбум төгрөгийн санхүүжилт хүссэн 26,454 төсөл ирүүлсний 18 хувьд буюу 7,536 төсөлд 835,2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосноор 40,628 ажлын байр шинээр бий болж, 25,417 ажлын байр хадгалагдсан бол Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн хүрээнд барьцаа баталгаа шаардлагатай 463 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн 102,2 тэрбум төгрөгийн зээлд 42,4 тэрбум төгрөгийн батлан даалт гаргажээ.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх, импортыг орлох, экспортыг дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор импортолж буй жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудыг 2009, 2014, 2017 онд баталж, хуулийн хүрээнд чөлөөлөгдөх тоног төхөөрөмжийн жагсаалтыг Засгийн газрын 2014 оны 191, 2017 оны 168 дугаар тогтоолоор баталсан. Дээрх тогтоолын хүрээнд 2009-2016 онд нийт 2,899 иргэн, аж ахуйн нэгж 3,201 төрлийн 7 мянга гаруй ширхэг тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг импортолсон бөгөөд 37,5 тэрбум төгрөгийн гаалийн, 78,8 тэрбум төгрөгийн нэмэгдсэн өртгийн татварын чөлөөлөлтөд тус тус хамрагдсан байна.

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг хэрэгжүүлснээр иргэдийн бизнес эрхлэх хүсэл эрмэлзэл нэмэгдэж, дотооддоо импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж улмаар экспортлох сонирхол ихээр төрж байгаа бөгөөд дэмжлэгт хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн бүтээмж 20-30 хувь нэмэгдсэн нь судалгаанаас харагдаж байна.

Улс орны эдийн засаг эрчимтэй хөгжиж, зах зээлийн харилцаа гүнзгийрэх тусам Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг шинэчлэх, зохицуулалтыг өөрчлөх зайлшгүй шаардлага гарсаар байна. Иймд Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих, хөгжүүлэх талаар тусгасан зорилтуудтай уялдуулан жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлж буй олон улсын туршлага, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Эдийн засаг хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын зөвлөмж, жижиг, дунд үйлдвэрийн салбарт хийсэн ажиглалт судалгааны дүгнэлт, өөрийн орны онцлог, давуу, сул тал, эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын орчин, түүхий эд, хүний нөөцийн боломж зэргийг харгалзан боловсруулснаас гадна хуулийн төсөл боловсруулалтын шатанд “Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах” судалгааг хийж, судалгааны тайлангийн зөвлөмжид үндэслэн дараахь асуудлыг хуулийн төсөлд тусгалаа. Үүнд:

- Хуулийн зорилгыг жижиг, дунд үйлдвэрийг төрөлжүүлэн хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарын улс орны эдийн засагт эзлэх хувийг дээшлүүлэх зэрэг хэмжиж болохуйц байдлаар томьёолсон;

- Жижиг, дунд аж ахуйн нэгжийг тодорхойлох, ангилах асуудлыг тусгайлан зохицуулаагүй, өөр хоорондоо ялгамжгүй байдлаар тогтоосныг өөрчлөн нэр томъёо, ойлголтыг тодорхой болгосон;

- Хуулийн үйлчлэх хүрээнээс иргэнийг гаргаж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулиар иргэнийг хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх, улмаар үйл ажиллагаагаа өргөжүүлэн компани, хоршоо байгуулах замаар Жижиг, дунд бизнесийн дэмжлэгт хамрагддаг байх зарчмын шинжтэй өөрчлөлтийг тусгасан;

- Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд дэмжлэгийн талаарх бодлого, үндсэн чиглэлийг тусгасан тунхаглалын шинжтэй заалтууд хуулийн гуравны нэгтэй тэнцэж байгаа байдлыг өөрчлөн найруулсан;

- Ажил олгогч нарын ажлын байр шинээр бий болгох сонирхлыг эдийн засгийн хөшүүрэг ашиглан нэмэгдүүлж, ажилчдын тоо өсөх тусам Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас болон банкаар дамжуулж олгох зээлийн хэмжээ нэмэгддэг байх зохицуулалтыг тусгасан;

- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн ангилалд хамаарах аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг салбар харгалзахгүйгээр 1 хувь болгох, уг хуулийн үйлчлэлд хамаарч байгаа аж ахуйн нэгжүүд санхүүгийн тайлангаа улирал тутамд бус жилд нэг удаа хялбаршуулсан байдлаар гаргадаг байхаар хуулийн төсөлд тусгаллаа;

- Жил бүрийн улсын төсвийн нийт хөрөнгө оруулалтын тодорхой хэсгийг буюу 10 хувиас доошгүй мөнгөн хөрөнгийг жижиг, дунд бизнес эрхлэхэд зориулж Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санд төвлөрүүлэхээр зохицуулсан зохицуулалтыг боловсронгуй болгосон;

- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарын үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох өөрчлөлтийг оруулсан;

- Хууль зөрчсөн хүн, хуулийн этгээд, төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгон Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуультай уялдуулсан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийн эх бичвэрийн төслийг боловсруулан төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийж, Төрийн ордонд 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 800 гаруй жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарын дунд хэлэлцүүлэг зохион байгуулан олонхийн дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд тусгасан болно.

Хоёр. Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсантай холбогдуулан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсрууллаа.

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага:

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах дараахь хууль зүйн болон практик үндэслэл, шаардлага байна.

1.Хууль зүйн үндэслэл

Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ийн 2.2.1 дэх хэсгийн 2-т Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 66 хувьд, ажилгүйдлийн түвшинг 6 хувьд хүргэх, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, дэд бүтцийн томоохон төслүүдийн хөдөлмөрийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэх, төгсөгчид ажлын байрыг өөрөө бий болгоход чиглэсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг дэмжих, албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулах, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд 100 тэрбумаас доошгүй төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилтыг 2016-2020 онд хэрэгжүүлэхээр заасан байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.17-д “5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон хөнгөн, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ” гэж, 2.15-д “Итгэлийн зээлийг олгож, жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ” гэж, 2.48-д “... жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ” гэж, 2.50-д “Хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү, зээлийн уян хатан бодлого хэрэгжүүлнэ” гэж тус тус заажээ.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 186-д “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг боловсруулах, ингэхдээ жижиг, дунд үйлдвэрийн ангиллыг өөрчлөх, өнөөгийн бодит байдалтай уялдуулан оновчтой тодорхойлох, жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжих, төрөөс жижиг, дунд үйлдвэрт үзүүлэх дэмжлэгийг оновчтой болгох эрх зүйн орчинг бүрдүүлэхээр заасан нь хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл болно.

2.Практик шаардлага

Улс орны эдийн засаг эрчимтэй хөгжиж, зах зээлийн харилцаа гүнзгийрэхийн хэрээр одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг шинэчлэх, зохицуулалтыг дараахь чиглэлээр өөрчлөх зайлшгүй шаардлага гарч байна. Үүнд:

1/Хуулийн зорилтыг өөрчлөх

Одоогийн мөрдөж байгаа хуулийн зорилт хэт ерөнхий байгааг өөрчлөн хуулийн зорилго, зорилтыг ялгаж, нарийвчлах болно. Хуулийн зорилгыг жижиг, дунд үйлдвэрийг төрөлжүүлэн хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарын улс орны эдийн засагт эзлэх хувийг дээшлүүлэх зэрэг хэмжиж болохуйц байдлаар томьёолох ба зорилтын хувьд төрийн дэмжлэгийн хамрах хүрээ, хэлбэр, удирдлага, зохицуулалтын эрх зүйн үндсийг тодорхой болгохтой холбогдсон харилцааг уг хуулиар зохицуулахаар тусгана.

2/Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн ангиллыг тодорхой болгон шинэчлэх

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулиар бичил болон жижиг, дунд аж ахуйн нэгжийг тодорхойлох, ангилах асуудлыг тусгайлан зохицуулаагүй, өөр хоорондоо ялгамжгүй байдлаар тогтоосныг өөрчлөн нэр томьёо, ойлголтыг тодорхой болгох хэрэгцээ урган гарсаар удаж байна. Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд “бичил” үйлдвэр эрхлэгчийн ойлголтыг тусгасан нь салбарын бодлогын уялдаа алдагдахад хүргэж байх тул Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн үйлчлэх хүрээнээс иргэнийг гаргаж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулиар иргэнийг хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх, улмаар үйл ажиллагаагаа өргөжүүлэн компани, хоршоо байгуулах замаар Жижиг, дунд бизнесийн дэмжлэгт хамрагддаг байх зарчмын шинжтэй өөрчлөлтийг тусгах нь зүйтэй гэж үзлээ.

Иймд “бичил үйлдвэр эрхлэгч”-д 9 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, 250 сая төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг; “жижиг үйлдвэр эрхлэгч”-д 10-50 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, 250-500 сая төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг; “дунд үйлдвэр эрхлэгч”-д 50-200 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, 500 сая-2,5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг хамруулах нь оновчтой болох юм.

3/Дэмжлэгийг оновчтой болгох, татварын таатай орчныг бүрдүүлэх

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд бодлого, үндсэн чиглэлийг тусгасан тунхаглалын шинжтэй заалтууд хуулийн гуравны нэгтэй тэнцэж байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байх гол шалтгаануудын нэг болж байна.

Бизнес эрхлэлтийг дэмжих хүрээнд татварын таатай орчныг бүрдүүлэх, хөнгөлөлттэй санхүүжилт, мэдээллийн хүртээмж, сургалт, зөвлөгөөний цар хүрээг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, үйлдвэрлэл технологийн төв байгуулах, зах зээл нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байна. Тухайлбал, ажил олгогч нарын ажлын байр шинээр бий болгох сонирхлыг эдийн засгийн хөшүүрэг ашиглан нэмэгдүүлж, ажилчдын тоо өсөх тусам зээлийн хэмжээ нэмэгдэх, шинээр бий болгосон ажлын байрны тоо болон борлуулалтын орлогын хэмжээ нэмэгдсэн байдлыг харгалзан Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас олгох зээлийн хүүгийн хэмжээг бууруулах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах ба бичил, жижиг үйлдвэр эрхлэгчид олгох зээлийг сангаас шууд, дунд үйлдвэр эрхлэгчид банкаар дамжуулан зээл олгох нь зүйтэй байна.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн ангилалд хамаарах аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг салбар харгалзахгүйгээр 1 хувь болгох, уг хуулийн үйлчлэлд хамаарч байгаа аж ахуйн нэгжүүд санхүүгийн тайлангаа улирал тутамд бус жилд нэг удаа хялбаршуулсан байдлаар гаргадаг болох шаардлагатай.

Түүнчлэн жил бүрийн улсын төсвийн нийт хөрөнгө оруулалтын тодорхой хэсгийг буюу 10 хувиас доошгүй хувийг жижиг, дунд бизнес эрхлэхэд зориулах талаархи тусгайлсан зохицуулалтыг бий болгох нь үйлдвэрлэл эрхлэгчдэд бодит дэмжлэг болно гэж үзэж байна.

4/Дотоодын худалдан авалт, гадаад зах зээлийг өргөтгөх

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарын үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, нэмэгдүүлэх нь хамгийн чухал асуудлын нэг болоод байгаа бөгөөд нөгөө талаас үйлдвэрлэгч нарын хөдөлмөрийн бүтээмж, бүтээгдэхүүний чанар, нэр төрлийг сайжруулах шаардлагатай байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд холбогдох өөрчлөлтийг оруулж, дотоодын худалдан авалтын 10-аас доошгүй хувийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарын бүтээгдэхүүнээр хангах, тэдэнд давуу эрх олгох шаардлагатай байна.

Мөн уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн жилийн нийт худалдан авалтынхаа 10-аас доошгүй хувийг олборлолт, хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутгийнхаа бизнес эрхлэгчдээс худалдан авах, ийнхүү худалдан аваагүй тохиолдолд тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих санд шилжүүлдэг байх зохицуулалтыг хуульд оруулах хэрэгтэй байна. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих санд хуримтлагдсан уг мөнгөн хөрөнгийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарын үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, олон улсын стандартад нийцүүлэх, нэр төрлийг нэмэгдүүлэх зэрэг бодлогын асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах нь зүйтэй гэж үзэж байна.

5/Жижиг, дунд үйлдвэрийг бүсчлэн хөгжүүлэх

Орон нутгийн онцлог, түүхий эдийн нөөцөд тулгуурлан төвлөрлийг сааруулах, орон нутагт бизнес эрхлэх санаачлагыг дэмжихэд тухайн бүс нутгийг төрөлжүүлэн хөгжүүлэх асуудал нэн шаардлагатай байна. Азийн бусад оронд тухайлбал, Японд “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн”, БНСУ-д “Шинэ тосгон” хөдөлгөөн өрнүүлж, БНХАУ-д “Нэг сум-Нэг эрдэнэс-Нэг салбар” буюу тухайн төвлөрсөн хот сууринг тавилга, шил үйлдвэрлэлийн зэрэг тодорхой салбар, чиглэлээр амжилттай төрөлжүүлэн хөгжүүлж байгаа олон улсын туршлагаас жишээ авч, жижиг, дунд үйлдвэрийг нэмүү өртөг шингэсэн, кластераар хөгжүүлэх бодлогыг уг хуульд тусгах шаардлагатай байна.

6/Бодлогыг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны тайлангаар Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомж, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих төрийн захиргааны байгууллага тогтворгүй, бүтцийн болон чиг үүргийн хувьд богино хугацааны давтамжтай өөрчлөгдөж байгаа нь энэ талаархи бодлого хангалтгүй хэрэгжихэд хүргэж байна гэж дүгнэсэн.

2012 онд Жижиг, дунд үйлдвэрийн газрыг татан буулгасан нь Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа нийт иргэдийн 60 гаруй хувийг эзэлж байгаа жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарт нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих, санхүүгийн төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагаагаар хамтран бүсчлэн хөгжих, зөвлөгөө, мэдээллээр хангагдах, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлэх зэрэг олон чухал бодлого, хөтөлбөрийг нэгдсэн удирдлагаар хангаж, бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна.

Салбарын тусгай сангууд нь тусдаа удирдлагатай, өөр чиг үүргийн яамдуудад харьяалагдаж буй одоогийн бүтэц нь нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, сангийн хөрөнгө зорилтот бүлэгт хүрч байгаа эсэхийг хянах боломжийг хязгаарлаж байна. Иймд бүтцийг нэгтгэн, тэдгээр сангуудад ажиллаж байгаа албан хаагчдын цалингийн сан дээр үндэслэн улсын төсөвт бага ачаалал үүсгэх байдлаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газрыг байгуулах хууль зүйн үндэслэлийг бий болгох шаардлагатай байна.

7/ Хуулийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах

Хууль зүйн яамнаас 2015 онд хийсэн “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн давхардал, зөрчил, хийдлийн талаарх судалгааны тайлан”-д тусгагдсан хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах тухай дүгнэлттэй холбогдуулан Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн зарим зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Хуулийн нийт заалтын тавиас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасныг үндэслэн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд уг хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараахь байдлаар тусгана. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилго, зорилт, зохицуулах харилцааг өргөтгөн өөрчлөх, нэр томъёог олон улсад хэрэглэж заншсан, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх өөрчлөлтүүдийг тусгана.

Хоёрдугаар бүлэгт жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн ангилал, бүртгэлтэй холбоотой зохицуулалтыг тусгана. Тухайлбал, жижиг, дунд үйлдвэрт хамаарахгүй этгээдийг нарийвчлан зааг ялгааг тодорхой болгосноор зээл, дэмжлэг эзнээ олох боломж нэмэгдэнэ.

Гуравдугаар бүлэгт жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төрийн бодлого, дэмжлэгийн хэлбэр, кластерийн үйл ажиллагаа, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн талаарх зүйл, заалтыг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт төрөөс жижиг, дунд үйлдвэрийн зах зээлийн харилцаанд оролцогчийн эрх, үүргийн талаарх зохицуулалтыг тусгана.

Тавдугаар бүлэгт жижиг, дунд үйлдвэрийн талаарх төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, мэдээллийн сангийн зохицуулалтыг тусгана.

Зургаадугаар бүлэгт жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага зэрэг бусад зохицуулалтыг тусгана.

Гурав. Хууль батлагдсанаар гарч болох нийгэм эдийн засаг, хууль зүйн үр дагавар, гарах үр дүнгийн талаар:

Хуулийн төсөл батлагдсанаар дараахь эерэг үр дүн гарна.

Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын чиг үүрэг, эрхлэх асуудал зохистой түвшинд хүрч, чиг үүргээ хараат бус байдлаар бие даан хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэнээр хуулийн хэрэгжилт сайжирна.

Бичил болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн ойлголтыг тодорхой болгосноор төрөөс үзүүлж буй дэмжлэгийг бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд ангиллын дагуу оновчтой хуваарилах боломж бүрдэж, улмаар бичлээс жижиг, жижгээс дунд, дундаас томоохон үйлдвэр, үйлчилгээ эрхлэлт рүү шилжих замаар жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн өрсөлдөх чадвар, нэмүү өртгийн сүлжээнд оролцогсдын тоо нэмэгдэхээс гадна үйл ажиллагаагаа өргөтгөх идэвх санаачилга бий болно.

Байгаль орчинд халгүй өндөр болон дэвшилтэт технологи нэвтэрч, нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөж, импортыг орлох, экспортод чиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжинө.

Жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлснээр Монгол Улс дахь бизнесийн орчин сайжрах боломж бүрдэж, гадаад дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэх, эдийн засгийн салбарууд хурдацтай хөгжихөд чухал нөлөө үзүүлнэ.

Татвар төлөгчдийн тоо нэмэгдэж, улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын хэмжээ нэмэгдэнэ.

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих байгууллагыг байгуулснаар төсөвт бага хэмжээний нэмэлт ачаалал ирэх боловч бодлогын хэрэгжилтийн үйл ажиллагааг бие дааж явуулах нөхцөл нь бүрдэх, удирдлагын болон боловсон хүчний мэргэшсэн тогтвортой байдал хангагдах давуу талтай юм. Улмаар тэдгээрийг дагаад хуулийн хэрэгжилт сайжирна. Хуулийн төсөл батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой хэмжээний хөрөнгийг улсын төсвөөс нэмж санхүүжүүлэх шаардлагатай. Энэхүү зардлыг тусгайлан тооцож төсөлд хавсаргана.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар:

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцүүлэн боловсруулах болно.

Уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, **Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай** хуулийн төсөл болон Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ...дугаар
сарын –ны өдөр

Улаанбаатар
хот

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ /шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилго, зорилт

1.1.Энэ хуулийн зорилго нь жижиг, дунд үйлдвэрийг төрөлжүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдгээрийн Монгол Улсын эдийн засагт эзлэх хувь оролцоог дээшлүүлэхэд чиглэнэ.

1.2.Энэ хуулийн зорилт нь жижиг, дунд үйлдвэрт үзүүлэх төрийн дэмжлэгийн хамрах хүрээ, хэлбэр, удирдлага, зохицуулалтын эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомж

2.1.Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², Компанийн тухай³, Хоршооны тухай⁴, Нөхөрлөлийн тухай⁵, Засгийн газрын тусгай сангийн тухай⁶, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга байрлан үйл ажиллагаа эрхэлдэг улсын бүртгэлд бүртгүүлсэн аж ахуйн нэгжид үйлчилнэ.

3.2.Төрийн бус байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой компани, улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой газар энэ хуулийн зохицуулалтад хамаарахгүй.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.”жижиг, дунд үйлдвэр эрхлэгч” гэж 200 хүртэл ажилтантай, 2.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлоготой, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг;

¹ Монгол Улсын Үндсэн хууль Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

² Иргэний хууль Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2002 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

³ Компанийн тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2011 оны 42 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Хоршооны тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 1998 оны 02 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Нөхөрлөлийн тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 1995 оны 08, 09 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Засгийн газрын тусгай сангийн тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2006 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

4.1.2.“борлуулалтын орлого” гэж аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд тодорхойлсон борлуулалтын орлогыг;

4.1.3.“ажилтан” гэж хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэнийг;

4.1.4.“кластер” гэж аж ахуйн нэгж нь үйлдвэрлэл, үйлчилгээний зорилго, төрөл, чиглэл, газарзүйн байршлын хувьд хорших, төрөлжих хэлбэрээр харилцан уялдаатай хамтран ажиллахыг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР ЭРХЛЭГЧ

5 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч

5.1.Дараахь нөхцөлийг зэрэг хангасан аж ахуйн нэгж жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид хамаарна.

5.1.1.“бичил үйлдвэр эрхлэгч”-д 9 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, 250 сая төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг;

5.1.2.“жижиг үйлдвэр эрхлэгч”-д 10-50 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, 250-500 сая төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг;

5.1.3.“дунд үйлдвэр эрхлэгч”-д 50-200 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, 500 сая-2,5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг.

5.2.Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн борлуулалтын орлогын хэмжээг тогтоохдоо түүнтэй харилцан хамаарал бүхий этгээдийн борлуулалтын орлогын хэмжээг нэгтгэн тооцно.

5.3.Аж ахуйн нэгж нь энэ хуулийн 5.1-д заасан нөхцөлийг зэрэг хангаагүй тохиолдолд ажилтны тоог голлох үзүүлэлт болгон зохих ангилалд хамааруулна.

5.4.Аж ахуйн нэгж нь хоёр ба түүнээс дээш чиглэлийн үйл ажиллагааг эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн аль нэг нь энэ хуулийн 7 дугаар зүйлд хамаарч байвал тухайн аж ахуйн нэгж нь энэ хуульд заасан жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид хамаарахгүй.

5.5.Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нь компани, хоршоо, нөхөрлөлийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулна.

6 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг бүртгэх

6.1.Энэ хуульд заасан нөхцөлийг хангасан тохиолдолд жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нь бүртгүүлэх хүсэлтээ жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутаг дахь тухайн асуудал хариуцсан эрх бүхий этгээдэд цаасаар, эсхүл цахимаар гаргана.

6.2.Энэ хуулийн 6.1-д заасан хүсэлтэд дараахь бичиг баримтыг хавсаргана:

6.2.1.улсын бүртгэлийн гэрчилгээ;
6.2.2.ажилтныг нийгмийн даатгалд хамруулсан тухай нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт;

6.2.3.эхлэлтийн баланс, эсхүл өмнөх жилийн санхүүгийн тайлан.

6.3.Хүсэлт гаргагч энэ хуулийн 5.1-д заасан нөхцөлийг хангасан гэж үзвэл хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор түүнийг зохих ангиллын жижиг, дунд үйлдвэр эрхлэгчээр бүртгэж, тодорхойлолт олгоно.

6.4.Хүсэлт гаргагч энэ хуулийн 5.1-д заасан нөхцөлийг хангаагүй, эсхүл бичиг баримтын бүрдэл дутуу байвал ~~энэ хуулийн 6.5-д заасан этгээд~~ үндэслэл бүхий бүртгэхээс татгалзсан хариуг ажлын 5 өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ.

6.5.Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн бүртгэл, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага албан ёсны цахим хуудсаар дамжуулан тухай бүр нийтэд мэдээлнэ.

6.6. Жижиг, дунд үйлдвэрийн ажилтны тоо, борлуулалтын орлогын хэмжээ нь энэ хуулийн 4.1.1-д заасан хязгаараас хэтэрсэн тохиолдолд жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн аж ахуйн нэгжийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн бүртгэлээс хасна.

6.7.Аж ахуйн нэгжийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгчээр бүртгэх үйлчилгээ үнэ төлбөргүй байна.

7 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид хамаарахгүй этгээд

7.1.Дараахь үйл ажиллагааг эрхэлдэг аж ахуйн нэгж энэ хуульд заасан жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид хамаарахгүй:

7.1.1.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн⁷ 15.2, 15.3, 15.4, 15.5, 15.6, 15.7, 15.8, 15.9, 15.10.4-15.10.14, 15.10.16-15.10.22, 15.11.1-15.11.2, 15.11.6, 15.12.4-15.12.6-15.12.11, 15.13.1, 15.14.3, 15.14.7, 15.15.1-15.15.1-15.15.11, 15.16, 15.18.2-15.18, 15.19, 15.20, т заасан үйл ажиллагаа;

7.1.2.барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ;

7.1.3.зуучлалын үйлчилгээ;

7.1.4.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн⁸ 13.4, 13.5-д заасан үйл ажиллагаа;

7.1.5.худалдаа, үйлчилгээний сүлжээ;

7.1.6.ашигт малтмал хайх, газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, боловсруулах.

⁷ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2001 оны 06 дугаарт нийтлэгдсэн.

⁸ Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2011 оны 46 дугаарт нийтлэгдсэн.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ ТӨРИЙН БОДЛОГО

8 дугаар зүйл. Төрөөс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар баримтлах бодлогын чиглэл

8.1. Бичил, жижиг, дунд үйлдвэрийн үйл ажиллагааны цар хүрээ, хөгжлийн үе шат, бүс нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө, гадаад зах зээлд нэвтрэх чадамж, техник, технологийн байдлыг нь харгалзан төрөөс дараахь чиглэлийн дэмжлэгийг үзүүлнэ:

8.1.1. жижиг, дунд үйлдвэрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээ шаардлагыг үндэслэн жижиг, дунд үйлдвэрийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах тогтолцоог хөгжүүлэх;

8.1.2. санхүүгийн дараахь дэмжлэгийг үзүүлэх:

8.1.2.а. хөнгөлөлттэй зээл олгох;

8.1.2.б. шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах;

8.1.2.в. зээлийн батлан даалт гаргах;

8.1.2.г. зээлийн хүүгийн зөрүүг олгох;

8.1.2.д. тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг үзүүлэх.

8.1.3. татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх;

8.1.4. экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг дэмжих;

8.1.5. бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлэх;

8.1.6. бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх;

8.1.7. шинэ технологийн судалгааг дэмжих;

8.1.8. техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

8.1.9. түүхий эдийн нөөц, орон нутгийн онцлогоос хамааран жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн харилцан уялдаа бүхий хамтын үйл ажиллагааг дэмжих;

8.1.10. гадаад, дотоод зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх.

9 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэрийн кластерийн үйл ажиллагааг дэмжих

9.1. Аж ахуйн нэгжийг кластераар хөгжүүлэхэд төрөөс дараахь дэмжлэгийг үзүүлнэ:

9.1.1. түүхий эдийн бэлтгэл, нийлүүлэлт, үйлдвэрлэл, тээвэрлэлт, борлуулалтын харилцан уялдаа бүхий үйл ажиллагаанд татвар, санхүүгийн цогц дэмжлэг үзүүлэх;

9.1.2. дэд бүтцийн хангамжийг сайжруулах;

9.1.3. үйл ажиллагаагаараа хорших, төрөлжих, хамтран ажиллах чиглэлийг тогтоож, зохион байгуулалтад оруулах.

10 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөр

10.1. Дунд хугацаанд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд баримтлах тэргүүлэх чиглэл, инноваци, техник, технологи дамжуулалт, нутагшуулалтыг эрчимжүүлэх, ажлын байр болон санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хүний нөөцийг чадавхижуулах, зах зээлийг өргөтгөхөд чиглэсэн хөтөлбөртэй байна.

10.2.Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, дүгнэхэд эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог хангана.

11 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

11.1.Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх зорилго бүхий Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан /цаашид “Сан” гэх/ байна.

11.2.Сангийн бүтэц, зохион байгуулалт, дүрмийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.3.Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна.

11.4.Санд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 14.2-т заасны дагуу улсын төсвөөс жил бүр хөрөнгө хуваарилна.

11.5.Сангаас хөнгөлөлттэй зээл олгох, баталгаа, батлан даалт гаргах, төсөл сонгон шалгаруулах журмыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 14.2.-т заасны дагуу Засгийн газар батална.

11.6.Сангаас жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид нэг удаа олгох зээлийн хэмжээг доор дурдсанаар тодорхойлно:

11.6.1.бичил үйлдвэр эрхлэгчид жилийн борлуулалтын орлогоос хамааруулан 250.0 сая төгрөг хүртэл;

11.6.2.жижиг үйлдвэр эрхлэгчид жилийн борлуулалтын орлогоос хамааруулан 500.0 сая төгрөг хүртэл;

11.6.3.дунд үйлдвэр эрхлэгчид жилийн борлуулалтын орлогоос хамааруулан 2.5 тэрбум төгрөг хүртэл.

11.7.Бичил, жижиг үйлдвэр эрхлэгчид олгох зээлийг Сангаас шууд, дунд үйлдвэр эрхлэгчид олгох зээлийг банкаар дамжуулж олгоно.

11.8.Дараахь жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид хөнгөлөлттэй зээл олгохгүй:

11.8.1.сангаас авсан зээлийн үлдэгдэлтэй;

11.8.2.зээлийн мэдээллийн санд муу зээлийн түүхтэй;

11.8.3.сангаас авсан зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон;

11.8.4.шүүхийн шийдвэрээр бусдад төлөх өртэй;

11.8.5.нийгмийн даатгал, татварын байгууллагад өртэй;

11.8.6.байгаль орчин ба хүний эрүүл мэндэд хортой технологи, түүхий эд, материал хэрэглэсэн, экологийн хохирол учруулсан нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон.

11.9.Зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн талаар санал дүгнэлт гаргах, сонгон шалгаруулалт явуулах, шийдвэр гаргахад аливаа этгээд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

11.10.Албан үүргээ гүйцэтгэхэд нь хөндлөнгөөс нөлөөлсөн гэж үзвэл тухайн албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй.

11.11.Сан төсөл сонгон шалгаруулсан буюу зээл олгосон шийдвэрийг үндэслэлийн хамт тухайн шийдвэр гарснаас хойш Сангийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан ажлын 5 өдрийн дотор нийтэд мэдээлнэ.

11.12.Төсөл сонгон шалгаруулсан буюу ~~зээл~~ санхүүгийн дэмжлэг олгосон шийдвэрийг энэ хуулийн 11.12-т заасны дагуу мэдээлснээс хойш ажлын 10 өдөр өнгөрсний дараахь өдрийг уг актыг албан ёсоор мэдэгдсэнд тооцно.

11.13.Сан нь зээлийн болон дамжуулан зээлдүүлэх гэрээний биелэлтэд хяналт тавина.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧ

12 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид үзүүлэх үйлчилгээ

12.1.Хувийн өмчит хуулийн этгээд дараахь үйлчилгээг жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид үзүүлж болно:

- 12.1.1.зөвлөгөө, мэдээллээр хангах;
- 12.1.2.бизнесийн зөвлөх үйлчилгээ;
- 12.1.2.сургалт зохион байгуулах;
- 12.1.3.борлуулалтыг дэмжих үйл ажиллагаа;
- 12.1.4.үйлдвэрлэлийн зориулалтаар ажлын байр, тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй нөхцөлөөр түрээслүүлэх;
- 12.1.5.бизнес инкубацийн үйлчилгээ.

12.2.Орон нутгийн зах зээл, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн энэ хуулийн 12.1-д заасан үйлчилгээг үзүүлэгч этгээдэд төр энэ хуульд заасан дэмжлэгийг үзүүлж болно.

13 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн эрх, үүрэг

13.1.Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч дараахь эрх эдэлнэ:

13.1.1.жижиг, дунд үйлдвэр, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих талаар төрөөс хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд хамрагдах, санхүүгийн дэмжлэг авах;

13.1.2.төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус аливаа шийдвэр, шаардлагыг биелүүлэхээс татгалзах, зохих журмын дагуу гомдол гаргах;

13.1.3.жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зориулан энэ хуулийн 13.1-д заасан этгээдээс болон төрийн, төрийн бус байгууллагаас зохион байгуулж байгаа сургалтад хамрагдах, мэдээлэл, зөвлөгөө авах;

13.1.4.жигжиг, дунд үйлдвэрийн талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрийн төсөлд санал өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;

13.1.5.хуульд заасан бусад эрх.

13.2.Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч дараахь үүрэг хүлээнэ:

13.2.1.хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэр, шаардлагыг биелүүлэх;

13.2.2.зохих стандарт, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх;

13.2.3.байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, дэвшилтэт техник, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;

13.2.4.бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанарыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх;

13.2.5.ажиллагчдын мэдлэг, туршлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, удирдлага, менежментийн арга барилыг сайжруулах;

13.2.6.ажиллагчдын нийгмийн хамгааллын баталгааг хангах, хуулиар тогтоосон хэмжээнээс доошгүй цалин хөлс олгох;

13.2.7.ажилтны тоо, борлуулалтын орлогын хэмжээ энэ хуулийн 4.1.1-д заасан хязгаараас хэтэрсэн бол энэ тухай жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутаг дахь тухайн асуудал хариуцсан эрх бүхий этгээдэд мэдэгдэх;

13.2.8.Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, зээлийн гэрээний үүргээ биелүүлэх;

13.2.9.Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас олгосон хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалтын явц, байдлын талаархи тайланг 6 сар тутамд Санд ирүүлэх;

13.2.10.хуулиар хүлээсэн бусад үүрэг.

ТАВДУГААР БҮЛЭГ **ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТАЛААРХИ ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН** **ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ**

14 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

14.1.Улсын Их Хурал жижиг, дунд үйлдвэрийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1.жигжиг, дунд үйлдвэр эрхлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, санхүү, татвар, зээл, хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн төрийн бодлогыг тодорхойлох;

14.1.2.жигиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг батлах;

14.1.3.жигиг, дунд үйлдвэрийн салбарт улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх;

14.1.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

15 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

15.1.Засгийн газар жигиг, дунд үйлдвэрийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1.жигиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийг 5 жилийн хугацаатай баталж, түүний хэрэгжилтийг хангах;

15.1.2.жигиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх чиглэлийг түүхий эдийн нөөц, эрэлт, хэрэгцээг харгалзан бүсчилэн батлах;

15.1.3.жигиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаадын зээл, тусламж, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөвт тусган шийдвэрлүүлэх;

15.1.4.жигиг, дунд үйлдвэрийг төрөөс дэмжихэд шаардагдах санхүүжилтийн нэмэлт хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Улсын Их Хурлын зөвшөөрлөөр Засгийн газрын үнэт цаас гаргах;

15.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

16 дугаар зүйл. Жигиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

16.1.Жигиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1.жигиг, дунд үйлдвэрийн хууль тогтоомж, энэ хуулийн 9 дүгээр зүйл, 15.1.2-т заасан хөтөлбөр, бичиг баримтын төслийг боловсруулах, биелэлтэд хяналт тавих;

16.1.2.жигиг, дунд үйлдвэрийн салбарт улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө, Жигиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, зээлийн батлан даалтын санг төрийг төлөөлөн нэгдсэн удирдлага, бодлогоор хангах;

16.1.3.жигиг, дунд үйлдвэр эрхлэгчид үзүүлэх төрийн үйлчилгээг нээлттэй, шуурхай хүргэх, шат дамжлагыг багасгах, хяналт шалгалт, бүртгэл, зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох санал боловсруулж шийдвэрлүүлэх;

16.1.4.энэ хуулийн 17.1.6-д заасан судалгааны тайланг үндэслэн салбартаа шаардлагатай хүний нөөцийн асуудлыг мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх талаархи төлөвлөгөө, үндсэн чиглэл, хөтөлбөр, суралцагч элсүүлэх мэргэжлийн чиглэлд тусгах;

16.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

16.2.Жижиг, дунд үйлдвэрийн талаархи энэ хуульд заасан төрийн зарим чиг үүргийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төрийн бус байгууллагад шилжүүлж болно.

17 дугаар зүйл. Жижиг дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

17.1.Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1.жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг хангахад чиглэсэн хууль тогтоомж, төрийн бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах;

17.1.2.эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авах;

17.1.3.жижиг, дунд үйлдвэрийн зах зээлийн оролцогчидтой харилцах, мэдээлэл солилцох, нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх;

17.1.4.энэ хуулийн 13.1-д заасан этгээдийг зөвлөгөө, мэдээллээр хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;

17.1.5.жижиг, дунд үйлдвэрийг дэмжих цахим мэдээллийн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх;

17.1.6.жижиг, дунд үйлдвэрт шаардлагатай хүний нөөцийн судалгааг жил бүр хийж, үр дүнг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;

17.1.7.жижиг, дунд үйлдвэрийн талаархи судалгааг тогтмол хийж, тэдгээрийг хөгжүүлэх, дэмжихтэй холбогдсон санал боловсруулж шийдвэрлүүлэх;

17.1.8.жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зориулсан үндэсний болон олон улсын хэмжээний үзэсгэлэн, худалдаа, чуулга уулзалт зохион байгуулах;

17.1.9.жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;

17.1.10.хариуцсан асуудлаар шаардлагатай мэдээ, судалгаа, холбогдох бусад бичиг баримтыг аж ахуйн нэгж, байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

17.1.11.цахим худалдаа нэвтрүүлэх, зохион байгуулах;

17.1.12.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

18 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын бүрэн эрх

18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жижиг, дунд үйлдвэрийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.1.1. тухайн шатны жил бүрийн төсөвт жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зориулалтаар хөрөнгө тусгаж батлах;

18.1.2. тухайн нутаг дэвсгэрт жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн хөтөлбөр батлах, хэрэгжилтэд хяналт тавих.

18.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга жижиг, дунд үйлдвэрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх арга хэмжээг орон нутагт зохион байгуулах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

19 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх

19.1. Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жижиг, дунд үйлдвэрийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.

19.2. Хяналт шинжилгээ, үнэлгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн⁹ 50, 51 дүгээр зүйл, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн¹⁰ 20.2-т заасны дагуу хийж, тайланг Засгийн газарт хүргүүлнэ.

19.3. Энэ хуулийн 19.1-д заасан хяналт, шинжилгээ, үнэлгээг хийхэд шаардлагатай мэдээллийг цуглуулах, судалгаа, шинжилгээ хийх, жижиг, дунд үйлдвэрийн зах зээлийн оролцогчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах, санал зөвлөмжийг авах ажлыг жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.

19.4. Хэрэгжилтийн тайланг хяналт шинжилгээ, үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлж болох ба шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

20 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэрийн цахим мэдээллийн сан

20.1. Жижиг, дунд үйлдвэрийн цахим мэдээллийн сан /цаашид “Мэдээллийн сан” гэх/ нь дараахь мэдээллээс бүрдэнэ:

20.1.1. жижиг, дунд үйлдвэрийн хууль тогтоомж, төрийн байгууллага, албан тушаалтнаас гаргасан холбогдох бусад эрх зүйн актууд;

20.1.2. техник, технологийн хөгжил, зах зээлийн мэдээлэл;

20.1.3. гадаад, дотоодын жижиг, дунд үйлдвэрийн сайн туршлага;

20.1.4. эрдэм шинжилгээний байгууллага, судлаачдын тайлан, бүтээл;

20.1.5. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалга;

20.1.6. жижиг, дунд үйлдвэрийг санхүүжүүлэх гадаад, дотоодын буцалтгүй тусламж, зээлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн талаархи мэдээлэл;

20.1.7. жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зориулан гадаад, дотоодод зохион байгуулах үзэсгэлэн, худалдааны тухай мэдээлэл;

20.1.8. хуулиар нууцад хамааруулаагүй бусад мэдээлэл.

⁹ Хууль тогтоомжийн тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2015 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

¹⁰ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2015 оны 47 дугаарт нийтлэгдсэн.

20.2.Мэдээллийн сан нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн эрэлт, нийлүүлэлт, хэрэгцээ, шаардлагыг холбох цахим хөтөчтэй байна.

20.3.Мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, мэдээлэл цуглуулах, үйлчилгээ үзүүлэх журмыг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

21 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

21.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд¹¹ заасан хариуцлага хүлээлгэнэ.

21.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд¹² заасан хариуцлага хүлээлгэнэ.

23.3.Энэ хуулийн 6.3, 6.4, 11.5, 11.6, 11.7, 11.8, 11.9, 11.12-т заасныг зөрчсөн буруутай албан тушаалтныг Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулна.

23.4.Албан тушаалтан энэ хуулийн 11.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн¹³ 29.2.2-т заасан, энэ хуулийн 11.10-д заасныг зөрчсөн бол мөн хуулийн 29.2.4-т заасан хариуцлага хүлээлгэнэ.

Гарын үсэг

¹¹ Зөрчлийн тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

¹² Төрийн албаны тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

¹³ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2012 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны...дугаар
Улаанбаатар
сарын...-ны өдөр

ХОТ

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2007 оны 07 дугаар сарын 27-ны өдөр баталсан Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 201... оны дугаар сарын.. -ны өдөр баталсан Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.6 дахь хэсэг, мөн зүйлийн 14.5.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг:

“14.2.Энэ хуулийн 7.1.1-д заасан жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд жил бүр улсын төсвөөс хуваарилах хөрөнгийн хэмжээ нь тухайн жилийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын 10 хувиас доошгүй байна.”

2/14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэг:

“14.6.Сангаас хөнгөлөлттэй зээл олгох, баталгаа, батлан даалт гаргах, төсөл сонгон шалгаруулах журмыг Засгийн газар батална.”

3/14 дүгээр зүйлийн 14.5.6 дахь заалт:

“14.5.6.тоног төхөөрөмж худалдан авахад санхүүгийн түрээсийн дэмжлэг үзүүлэх;”

2 дугаар зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэг:

“7.7. Энэ хуульд заасан 1 хувийн албан татвар ногдуулах татвар төлөгчийн албан татвар ногдох орлогыг тооцохдоо тухайн албан татвар төлөгч болон түүнтэй харилцан хамаарал бүхий этгээдийн албан татвар ногдох орлогын нийлбэр дүнгээр тооцно.”

2/12 дугаар зүйлийн 12.1.37 дахь заалт:

“12.1.37.Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санд өгсөн хандив.”

3/16 дугаар зүйлийн 16.2¹ дэх хэсэг:

“16.2¹.Энэ хуулийн 8.1.1, 8.1.6-8.1.9, 9.1.1-д заасан албан татвар ногдох орлогын нийт дүнгээс 12 дугаар зүйлд заасан зардлыг хасч, мөн хуулийн 17.1-д заасан албан татвар төлөгчийн албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.”

4/17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“17.1.Татвар төлөгч нь энэ хуулийн 16.2¹, 16.8, 16.9-д заасны дагуу тодорхойлоход 0-2.5 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 1 хувиар албан татвар ногдуулна.”

5/17 дугаар зүйлийн 4 дэх хэсэг

“17.4.Энэ хуулийн 17.1-д заасан татвар төлөгчийн Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 7.1-д заасан үйл ажиллагаанаас олсон татвар ногдуулах орлогод энэ хуулийн 17.2-г заасан хувиар албан татвар ногдуулна.”

6/21 дүгээр зүйлийн 21.5, 21.6, 21.7 дахь хэсэг:

“21.5.Тайлант жилийн албан татвар ногдуулах орлого нь 2.5 тэрбум төгрөгөөс хэтрэхгүй албан татвар төлөгч нь жилд нэг удаа хялбаршуулсан татварын тайлан гаргана.

21.6.Хялбаршуулсан татварын тайлан гаргах заавар, маягыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

21.7.Энэ хуулийн 21.5-д заасан татвар төлөгч нь жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд тушааж, албан татварын жилийн эцсийн тооцоо хийнэ.

2 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “хасч” гэсний дараа ”энэ хуулийн 16.2-т заасан албан татвар төлөгчийн” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “0-3.0 тэрбум” гэснийг “2.5-3.0 тэрбум” гэж, “17.1, 17.2” гэсэн дугаарыг “17.2, 17.3” гэж, “17.2.1-17.2.10” дахь дугаарыг “17.3.1-17.3.10” гэж, 18.1.2 дахь заалтын “17.2.1” гэснийг “17.3.1” гэж, 18.2 дахь хэсгийн “17.2.8” гэснийг “17.3.8” гэж, 18.1.2 заалтын “17.1” гэснийг “17.2” гэж, 21.5 дахь хэсгийн “17.2.1-17.2.3, 17.2.7-17.2.9” гэснийг “17.3.1-17.3.3, 17.3.7-17.3.9” гэж, “21.5, 21.6, 21.7, 21.8, 21.9” гэсэн хэсгийн дугаарыг “21.8, 21.9, 21.10, 21.11, 21.12” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.14, 19.15, 19.16, 19.17 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/10 дугаар зүйлийн 10.1.8 дахь заалт:

“10.1.8.Энэ хуулийн 10.1.1-д заасан дотоодын үйлдвэр эрхлэгчийн шаардлага хангасан тендерийг харьцуулан үнэлэхэд Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 5.1-д заасан жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид давуу эрх олгоно.

2/34 дүгээр зүйлийн 34.1.10 дахь заалт:

“34.1.10.энэ хуулийн 10¹.2-д заасан дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтад орсон бараа, бүтээгдэхүүнийг Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 5.1-д заасан жижиг, дунд үйлдвэр эрхлэгч үйлдвэрлэсэн бол.”

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “10 хувиар,” гэсний дараа “энэ хуулийн 10.1.1-д заасан этгээд нь Жижиг дунд үйлдвэрийн тухай хуулийн 5.1-д заасан жижиг, дунд үйлдвэр эрхлэгч бол түүний ирүүлсэн тендерийн Монгол Улсын гарал үүсэлтэй барааны хэсгийн үнийг 15 хувиар,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны...дугаар
сарын...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь хэсэг нэмсүгэй:

“2.Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомжид заасан журмыг зөрчин хөнгөлттэй зээл авсан, батлан даалт гаргуулсан бол хүнийг нэг мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг 10 мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгон, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна.”

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1.Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нь контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо, жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 4.1.1-д заасан хязгаараас хэтэрснийг бүртгэх байгууллагад мэдэгдээгүй, эсхүл хуурамч бичиг баримт бүрдүүлэн бүртгүүлсэн, эсхүл хуульд заасан тайланг хугацаанд нь ирүүлээгүй буюу хуурамч тайлан гаргасан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч,” гэснийг, 12 дугаар зүйлийн гарчгийн болон 12.1, 12.2 дахь хэсгийн, 23 дугаар зүйлийн 23.1.7 дахь заалтын “бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч,” гэснийг, мөн зүйлийн 12.8.4 дэх заалтын “; бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.9.11 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль” гэсний өмнө “, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар

хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” хэсэгт “19.Жижиг, дунд үйлдвэрийн газар” гэж нэмсүгэй.

2.Энэ тогтоолыг Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар

хот

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:

1/Жижиг дунд үйлдвэрийн тухай хуульд заасан журам, зааврыг боловсруулан, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний дотор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх

2/Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бүртгэлийг хуульд нийцүүлэн бүртгэх, хуулийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах,

3/Жижиг, дунд үйлдвэрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, жижиг, дунд үйлдвэри эрхлэгчийн бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулан, үе шаттайгаар хэрэгжүүлэх

4/Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын агентлаг байгуулахтай холбогдуулан шаардлагатай зардал санхүүжилтийг Монгол Улсын 2019 оны төсөвт тусган, тооцож, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх

5/Жижиг дунд үйлдвэрийг дэмжих санг хуульд нийцүүлэн өөрчлөн зохион байгуулах, жижиг, дунд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа сангуудыг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудалд шилжүүлэх зохион байуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Д.Дамба-Очир/-нд даалгасугай.

3.Энэ тогтоолыг Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Ж.ГАНБААТАР

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага:

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах дараахь хууль зүйн болон практик үндэслэл, шаардлага байна.

1.Хууль зүйн үндэслэл

Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ийн 2.2.1 дэх хэсгийн 2-т Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 66 хувьд, ажилгүйдлийн түвшинг 6 хувьд хүргэх, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, дэд бүтцийн томоохон төслүүдийн хөдөлмөрийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэх, төгсөгчид ажлын байрыг өөрөө бий болгоход чиглэсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг дэмжих, албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулах, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд 100 тэрбумаас доошгүй төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилтыг 2016-2020 онд хэрэгжүүлэхээр заасан байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.17-д “5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон хөнгөн, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ” гэж, 2.15-д “Итгэлийн зээлийг олгож, жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ” гэж, 2.48-д “... жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ” гэж, 2.50-д “Хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү, зээлийн уян хатан бодлого хэрэгжүүлнэ” гэж тус тус заажээ.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 186-д “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг боловсруулах, ингэхдээ жижиг, дунд үйлдвэрийн ангиллыг өөрчлөх, өнөөгийн бодит байдалтай уялдуулан оновчтой тодорхойлох, жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжих, төрөөс жижиг, дунд үйлдвэрт үзүүлэх дэмжлэгийг оновчтой болгох эрх зүйн орчинг бүрдүүлэхээр заасан нь хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл болно.

2.Практик шаардлага

Улс орны эдийн засаг эрчимтэй хөгжиж, зах зээлийн харилцаа гүнзгийрэхийн хэрээр одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг шинэчлэх, зохицуулалтыг дараахь чиглэлээр өөрчлөх зайлшгүй шаардлага гарч байна. Үүнд:

1/Хуулийн зорилтыг өөрчлөх

Одоогийн мөрдөж байгаа хуулийн зорилт хэт ерөнхий байгааг өөрчлөн хуулийн зорилго, зорилтыг ялгаж, нарийвчлах болно. Хуулийн зорилгыг жижиг, дунд үйлдвэрийг төрөлжүүлэн хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарын улс орны эдийн засагт эзлэх хувийг дээшлүүлэх зэрэг хэмжиж болохуйц байдлаар томъёолох ба зорилтын хувьд төрийн дэмжлэгийн хамрах хүрээ, хэлбэр, удирдлага, зохицуулалтын эрх зүйн үндсийг тодорхой болгохтой холбогдсон харилцааг уг хуулиар зохицуулахаар тусгана.

2/Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн ангиллыг тодорхой болгон шинэчлэх

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулиар бичил болон жижиг, дунд аж ахуйн нэгжийг тодорхойлох, ангилах асуудлыг тусгайлан зохицуулаагүй, өөр хоорондоо ялгамжгүй байдлаар тогтоосныг өөрчлөн нэр томъёо, ойлголтыг тодорхой болгох хэрэгцээ урган гарсаар удаж байна. Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд “бичил” үйлдвэр эрхлэгчийн ойлголтыг тусгасан нь салбарын бодлогын уялдаа алдагдахад хүргэж байх тул Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн үйлчлэх хүрээнээс иргэнийг гаргаж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулиар иргэнийг хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх, улмаар үйл ажиллагаагаа өргөжүүлэн компани, хоршоо байгуулах замаар Жижиг, дунд бизнесийн дэмжлэгт хамрагддаг байх зарчмын шинжтэй өөрчлөлтийг тусгах нь зүйтэй гэж үзлээ.

Иймд “бичил үйлдвэр эрхлэгч”-д 9 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, 250 сая төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг; “жижиг үйлдвэр эрхлэгч”-д 10-50 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, 250-500 сая төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг; “дунд үйлдвэр эрхлэгч”-д 50-200 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, 500 сая-2,5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг хамруулах нь оновчтой болох юм.

3/Дэмжлэгийг оновчтой болгох, татварын таатай орчныг бүрдүүлэх

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд бодлого, үндсэн чиглэлийг тусгасан тунхаглалын шинжтэй заалтууд хуулийн гуравны нэгтэй тэнцэж байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байх гол шалтгаануудын нэг болж байна.

Бизнес эрхлэлтийг дэмжих хүрээнд татварын таатай орчныг бүрдүүлэх, хөнгөлөлттэй санхүүжилт, мэдээллийн хүртээмж, сургалт, зөвлөгөөний цар хүрээг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, үйлдвэрлэл технологийн төв байгуулах, зах зээл нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байна. Тухайлбал, ажил олгогч нарын ажлын байр шинээр бий болгох сонирхлыг эдийн засгийн хөшүүрэг ашиглан нэмэгдүүлж, ажилчдын тоо өсөх тусам зээлийн хэмжээ нэмэгдэх, шинээр бий болгосон ажлын байрны тоо болон борлуулалтын орлогын хэмжээ нэмэгдсэн байдлыг харгалзан Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас олгох зээлийн хүүгийн хэмжээг бууруулах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах ба бичил, жижиг үйлдвэр эрхлэгчид олгох зээлийг сангаас шууд, дунд үйлдвэр эрхлэгчид банкаар дамжуулан зээл олгох нь зүйтэй байна.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн ангилалд хамаарах аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг салбар харгалзахгүйгээр 1 хувь болгох, уг хуулийн үйлчлэлд хамаарч байгаа аж ахуйн нэгжүүд санхүүгийн тайлангаа улирал тутамд бус жилд нэг удаа хялбаршуулсан байдлаар гаргадаг болох шаардлагатай.

Түүнчлэн жил бүрийн улсын төсвийн нийт хөрөнгө оруулалтын тодорхой хэсгийг буюу 10 хувиас доошгүй хувийг жижиг, дунд бизнес эрхлэхэд зориулах талаархи тусгайлсан зохицуулалтыг бий болгох нь үйлдвэрлэл эрхлэгчдэд бодит дэмжлэг болно гэж үзэж байна.

4/Дотоодын худалдан авалт, гадаад зах зээлийг өргөтгөх

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарын үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, нэмэгдүүлэх нь хамгийн чухал асуудлын нэг болоод байгаа бөгөөд нөгөө талаас үйлдвэрлэгч нарын хөдөлмөрийн бүтээмж, бүтээгдэхүүний чанар, нэр төрлийг сайжруулах шаардлагатай байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд холбогдох өөрчлөлтийг оруулж, дотоодын худалдан авалтын 10-аас доошгүй хувийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарын бүтээгдэхүүнээр хангах, тэдэнд давуу эрх олгох шаардлагатай байна.

Мөн уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн жилийн нийт худалдан авалтынхаа 10-аас доошгүй хувийг олборлолт, хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутгийнхаа бизнес эрхлэгчдээс худалдан авах, ийнхүү худалдан аваагүй тохиолдолд тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих санд шилжүүлдэг байх зохицуулалтыг хуульд оруулах хэрэгтэй байна. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих санд хуримтлагдсан уг мөнгөн хөрөнгийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарын үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, олон улсын стандартад нийцүүлэх, нэр төрлийг нэмэгдүүлэх зэрэг бодлогын асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах нь зүйтэй гэж үзэж байна.

5/Жижиг, дунд үйлдвэрийг бүсчлэн хөгжүүлэх

Орон нутгийн онцлог, түүхий эдийн нөөцөд тулгуурлан төвлөрлийг сааруулах, орон нутагт бизнес эрхлэх санаачлагыг дэмжихэд тухайн бүс нутгийг төрөлжүүлэн хөгжүүлэх асуудал нэн шаардлагатай байна. Азийн бусад оронд тухайлбал, Японд “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн”, БНСУ-д “Шинэ тосгон” хөдөлгөөн өрнүүлж, БНХАУ-д “Нэг сум-Нэг эрдэнэс-Нэг салбар” буюу тухайн төвлөрсөн хот сууринг тавилга, шил үйлдвэрлэлийн зэрэг тодорхой салбар, чиглэлээр амжилттай төрөлжүүлэн хөгжүүлж байгаа олон улсын туршлагаас жишээ авч, жижиг, дунд үйлдвэрийг нэмүү өртөг шингэсэн, кластераар хөгжүүлэх бодлогыг уг хуульд тусгах шаардлагатай байна.

6/Бодлогыг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны тайлангаар Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомж, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих төрийн захиргааны байгууллага тогтворгүй, бүтцийн болон чиг үүргийн хувьд богино хугацааны давтамжтай өөрчлөгдөж байгаа нь энэ талаархи бодлого хангалтгүй хэрэгжихэд хүргэж байна гэж дүгнэсэн.

2012 онд Жижиг, дунд үйлдвэрийн газрыг татан буулгасан нь Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа нийт иргэдийн 60 гаруй хувийг эзэлж байгаа жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарт нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих, санхүүгийн төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагаагаар хамтран бүсчлэн хөгжих, зөвлөгөө, мэдээллээр хангагдах, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлэх зэрэг олон чухал бодлого, хөтөлбөрийг нэгдсэн удирдлагаар хангаж, бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна.

Салбарын тусгай сангууд нь тусдаа удирдлагатай, өөр чиг үүргийн яамдуудад харьяалагдаж буй одоогийн бүтэц нь нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, сангийн хөрөнгө зорилтот бүлэгт хүрч байгаа эсэхийг хянах боломжийг хязгаарлаж байна. Иймд бүтцийг нэгтгэн, тэдгээр сангуудад ажиллаж байгаа албан хаагчдын цалингийн сан дээр үндэслэн улсын төсөвт бага ачаалал үүсгэх байдлаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газрыг байгуулах хууль зүйн үндэслэлийг бий болгох шаардлагатай байна.

7/ Хуулийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах

Хууль зүйн яамнаас 2015 онд хийсэн “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн давхардал, зөрчил, хийдлийн талаарх судалгааны тайлан”-д тусгагдсан хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах тухай дүгнэлттэй холбогдуулан Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн зарим зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Хуулийн нийт заалтын тавиас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасныг үндэслэн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд уг хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараахь байдлаар тусгана. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилго, зорилт, зохицуулах харилцааг өргөтгөн өөрчлөх, нэр томъёог олон улсад хэрэглэж заншсан, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх өөрчлөлтүүдийг тусгана.

Хоёрдугаар бүлэгт жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн ангилал, бүртгэлтэй холбоотой зохицуулалтыг тусгана. Тухайлбал, жижиг, дунд үйлдвэрт хамаарахгүй этгээдийг нарийвчлан зааг ялгааг тодорхой болгосноор зээл, дэмжлэг эзнээ олох боломж нэмэгдэнэ.

Гуравдугаар бүлэгт жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төрийн бодлого, дэмжлэгийн хэлбэр, кластерийн үйл ажиллагаа, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн талаарх зүйл, заалтыг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт төрөөс жижиг, дунд үйлдвэрийн зах зээлийн харилцаанд оролцогчийн эрх, үүргийн талаарх зохицуулалтыг тусгана.

Тавдугаар бүлэгт жижиг, дунд үйлдвэрийн талаарх төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, мэдээллийн сангийн зохицуулалтыг тусгана.

Зургаадугаар бүлэгт жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага зэрэг бусад зохицуулалтыг тусгана.

Гурав. Хууль батлагдсанаар гарч болох нийгэм эдийн засаг, хууль зүйн үр дагавар, гарах үр дүнгийн талаар:

Хуулийн төсөл батлагдсанаар дараахь эерэг үр дүн гарна.

Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын чиг үүрэг, эрхлэх асуудал зохистой түвшинд хүрч, чиг үүргээ хараат бус байдлаар бие даан хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэнээр хуулийн хэрэгжилт сайжирна.

Бичил болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн ойлголтыг тодорхой болгосноор төрөөс үзүүлж буй дэмжлэгийг бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд ангиллын дагуу оновчтой хуваарилах боломж бүрдэж, улмаар бичлээс жижиг, жижгээс дунд, дундаас томоохон үйлдвэр, үйлчилгээ эрхлэлт рүү шилжих замаар жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн өрсөлдөх чадвар, нэмүү өртгийн сүлжээнд оролцогсдын тоо нэмэгдэхээс гадна үйл ажиллагаагаа өргөтгөх идэвх санаачилга бий болно.

Байгаль орчинд халгүй өндөр болон дэвшилтэт технологи нэвтэрч, нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөж, импортыг орлох, экспортод чиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжинө.

Жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлснээр Монгол Улс дахь бизнесийн орчин сайжрах боломж бүрдэж, гадаад дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэх, эдийн засгийн салбарууд хурдацтай хөгжихөд чухал нөлөө үзүүлнэ.

Татвар төлөгчдийн тоо нэмэгдэж, улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын хэмжээ нэмэгдэнэ.

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих байгууллагыг байгуулснаар төсөвт бага хэмжээний нэмэлт ачаалал ирэх боловч бодлогын хэрэгжилтийн үйл ажиллагааг бие дааж явуулах нөхцөл нь бүрдэх, удирдлагын болон боловсон хүчний мэргэшсэн тогтвортой байдал хангагдах давуу талтай юм. Улмаар тэдгээрийг дагаад хуулийн хэрэгжилт сайжирна. Хуулийн төсөл батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой хэмжээний хөрөнгийг улсын төсвөөс нэмж санхүүжүүлэх шаардлагатай. Энэхүү зардлыг тусгайлан тооцож төсөлд хавсаргана.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар:

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцүүлэн боловсруулах болно.

Уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

ХУУЛЬ САНААЧЛАГЧИД